

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Тус салбар зөвлөлөөс ерөнхий мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох эрхийг авсны дагуу 2013 онд ерөнхий мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулах журмыг Анхан шатны тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн 2013 оны 02 сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан бөгөөд Ерөнхий мэргэжилтний мэргэжлийн зэрэг горилох материалыг 2013 оны 03 сарын 15-ны дотор тус салбар зөвлөлд хүргүүлнэ үү хэмээн мэдэгдэж байна.

Үүнд:

1. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
2. Байгууллагын даргаар баталгаажуулсан мэргэжлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт / Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулсан загвараар /
3. Нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулах баримтууд
4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар
5. Өмнө нь мэргэжлийн зэрэг хамгаалсан бол үнэмлэхний эх хувь
6. Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхний хувь
7. 3*4 хэмжээний зураг 2%

2013 онд мэргэжлийн зэрэг горилох шалгалтанд эмч, мэргэжилтнүүдийг идэвхтэй хамруулахыг хүсэж байна.

Дарга:

ПРОФ.С.СОНИН

ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь ерөнхий мэргэжилтэний мэргэжлийн зэрэг олгох хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Ерөнхий мэргэжилтэн гэж Анагаах ухааны дээд, дунд боловсролтой өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ерөнхий мэргэжлийн эмч, бага эмч, сувилагч-бага эмчийн чиглэлээр эмчлэх, сувилах эрхтэй ажиллаж буй хүний их эмч, бага эмчийг хамруулна.
- 1.3. Мэргэжлийн зэрэг горилогч нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2011 оны 12 дугаар сарын 08 өдрийн 408 тоот тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 423 тоот тушаалыг тус тус уншиж судалсан байна.

Хоёр. Тусгай шалгуур үзүүлэлт

- 2.1. Ахлах зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна.
 - 2.1.1. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын 2.1.4-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас тодорхойлолт авсан байх /Харьяа дээд шатны байгууллагын хариуцсан албан тушаалтанаас авах/
 - 2.1.2. Ахлах зэрэг горилох их эмч дангаар буюу бусадтай хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх,
 - 2.1.3. Бага эмч нар өгүүлэл бичиж нийтлүүлэх, илтгэл бэлтгэж хэлэлцүүлэхэд биечлэн оролцсон байх
 - 2.1.4. Ажилласан жилдээ 2-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх
 - 2.1.5. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах
 - 2.1.6. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах
- 2.2. Тэргүүлэх зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна
 - 2.2.1. Энэхүү журмын 2.1.1-т заасан материалыг бүрдүүлэх
 - 2.2.2. Тэргүүлэх зэрэг горилох их эмч дангаар буюу бусадтай хамтран 5-аас доошгүй өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх
 - 2.2.3. Бага эмч нар **энэхүү журмын 2.1.3-т заасан болзлыг хангах**
 - 2.2.4. Ажилласан жилдээ 4-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх
 - 2.2.5. Энэхүү журмын 2.1.5-т заасан баримтыг хавсаргах
 - 2.2.6. Энэхүү журмын 2.1.6-т заасан дүнг хавсаргах
- 2.3. Зөвлөх зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна
 - 2.3.1. Энэхүү журмын 2.1.1-т заасан материалыг бүрдүүлэх
 - 2.3.2. Зөвлөх зэрэг горилох их эмч дангаар буюу бусадтай хамтран 8-аас доошгүй өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх

- 2.3.3. Ажилласан жилдээ 6-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх
- 2.3.4. Энэхүү журмын 2.1.5-т заасан баримтыг хавсаргах
- 2.3.5. Энэхүү журмын 2.1.6-т заасан дүнг хавсаргах
- 2.3.6. Удирдах ажлыг 5-аас доошгүй жил хийсэн байх, мэргэжлийн чиглэлээр зөвлөх эмчийн ур чадвар бүрэн эзэмшсэн болохыг хамт олон, харьяа дээд шатны байгууллагаас тус тус тодорхойлсон байх

Гурав: Мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалтын зохион байгуулалт

- 3.1. Ерөнхий мэргэжилтний мэргэжлийн зэргийн шалгалтыг 2013 оны 5 сарын 1-нээс 05 сарын 15-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулна.
- 3.2. Зэргийн шалгалтанд орох болзол хангасан эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалыг аймаг, нийслэлийн ЭМГазраар дамжуулан 3 сарын 15-ны дотор Анхан Шатны Тусламжийн Мэргэжлийн Салбар Зөвлөлийн /Клиникийн 1 дүгээр амаржих газрын Захиргааны 2 давхарт, Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтэнүүдийн Холбоо/ байранд хүлээн авна. /Харилцах утас 70115560, 99992913, 99066788/
- 3.3. Мэргэжлийн зэрэг горилогчийн материалыг Анхан Шатны Тусламжийн Мэргэжлийн Салбар Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, салбар зөвлөлийн гишүүд шалгаруулж зэрэг олгох шалгаруулалтанд орох эмнэлгийн мэргэжилтэний жагсаалтыг гарган зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталсны дараа 4 сарын 1-ны дотор Зөвлөлийн Ажлын Албанд хүргүүлнэ.
- 3.4. Ерөнхий мэргэжилтэний зэргийн шалгалтыг энэхүү журмын 3.1-д заасан хугацаанд тсмилсон комиссын бүрэлдэхүүнтэйгээр Эрүүл Мэндийн Яамны Мэргэжлийн Зөвлөлөөс төлөөлөл оролцуулан, зохион байгуулна.

Дөрөв. Мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааны санхүүжилт

- 4.1. Мэргэжлийн зэрэг олгох зардлыг нь ЭМСайд, Сангийн сайдын хамтарсан 2011 оны 12 сарын 16-ны өдрийн 423 тоот тушаалын 3, 4 хавсралтанд зааснаар мэргэжлийн зэрэг горилогч хариуцна.